МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гомбо-Ичин	Дугаар	L094
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Дэлгэрхаан
Төрсөн газар	Дэлгэрхаан сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Долоодын хийд	Сүм хийдийн дугаар	ХЭДХ 017
Одоогийн сүм хийд	Хэрлэнбаян дулаан Үржинханд Чойлин хийд	Сүм хийдийн дугаар	ХЭДХ 022
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 15	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Долоодын хийд

-Гомбо-Ичин гуайгаас Дэлгэрхаан сумын нутагт байсан сүм хийдийн талаар асууж ярилцъя?

Энэ шинэ хийдийн суурь чинь зодын хуралтай байсан. Манай энэ хүн ч зодын хүн.(Балжинням одоо хийдийг удирдаж байгаа хүн) Тэрнээс урьд нь бол шинийн 8, 15 гээд бүх өдрүүдэд хурдаг байсан. Энэ жилээс болиод байгаа юм. Зун ч хурж чадахгүй л байна. Хүүхдүүдийн зав чөлөө болдоггүй юм болов уу даа. Манай энд чинь Төв аймгийн Баянжаргалан, Багануур, Хэнтийн Баянмөнх, Дархан, Дорноговиос хүмүүс ирж байдаг. Манай энэ орон нутгийнхан хурал номдоо сайхан ирнэ штээ.

-Шинэ хийдэд байгуулагдсанаас хойш ямар нэгэн содон үйл явдал болж байсан уу?

Манайх чинь ч одоо тийм содон юм болоогүй. Анх хийд нээгдэхэд Ягааны Батмөнх гэж хүн бүр Дархан хотоос ирж 5,6 хүүхдэд сар хичээл заасан. Өглөө яг 8 цагт ирээд. Би хамгийн хөгшин нь байсан. Суулгасан хүүхдээс

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

хоёр нь л энд байдаг юм. Бусад нь өөр газарлуу шилжээд явсан байх. Намайг лам бол гэсэн. Би хүүхдүүдийн дэргэд яахав гээд ном судар уншъя гэсэн. Тийм хэдэн хүүхэд байсан. Төвдээр уншдаг нэг лам байсан. Тэр маань Багануур явсан.Би энийг байгуулснаас хойш сайн дурааараа тасралтгүй сууж байгаа хүн. Шинийн найман энэ тэрд хөл тасрахгүй шүү. Жаргалтхаан, Багануур энэ тэр өөрсдөө хуралтай мөртлөө тэндээс хүмүүс ирдэг. Ер нь манайх л байнгын хуралтай байх шив дээ.

-Мааньтын хийдийн талаар?

Мааньтын хийд гэдэг чинь олон сайхан лам нартай тэр үедээ том хийд байсан. Тэнд нэг отог бүгдээрээ нийлж орон нутгийнхаа ах дүү нар нийлж тэнд хурдаг байсан байна л даа. Сайхан хийд байсан. Нутаг хошуныхаараа нийлж тэнд хурдаг байсан байна л даа.Манайхны тэр чинь их хүндэтгэлтэй. Өндөр Гэгээн Занабазар чинь энд Дашчийравын сан уншсан л гэдэг юм. Нэг настай хөгшин ярьж байдаг юм. Жанлавцогзол гэдгийг чинь тэнд л айлдаж байсан.Тэр тухай бичсэн түүх ч гэж юу байхав. Зүгээр тэрүүгээр айлдаж л байсан. Тэр уул усыг аравнайлаад агуйд нь даяанч хийж тэгээд Очирт гэдэг уулыг аравнайлаад олон түмний сайн сайхны төлөө арц хүжээрээ уншлагагүй хайрлаж яваарай гэж захисан юм гэнэ лээ. Тийм л газар даа. Тэгээд Мааньтын хурал гэдэг чинь тэрүүгээрээ хүчтэй байсан юм.

-Өндөр гэгээний Хорио гэдэг чинь хаана байсан юм бэ?

Өндөр Гэгээний Хорио гэдэг чинь сая хажуугаар нь гарсан ууланд бий. Тэнд чинь Өндөр гэгээний хөрөг байдаг юм. Нэг талаараа гардаг. Одоо тэрийг манай настай улсууд мэднэ. Жамсранжав гэдэг хүн тэрийг мэднэ.Тэр агуйд нь орж байсан. Би эрээд олдоггүй юм. Машин байвал заагаад өгч болно гэдэг. Олон сайхан лам нартай байсан. Жисаа энэ тэр гээд бүх юмыг л хийдэг байсан гэж байгаа. Хаа газрын хурал болгон л тэгдэг байсан биз дээ.

-Хөхтийн хийдийн талаар сонссон юм байна уу?

Үнэндээ сонссон юм байхгүй.Том л хийд л байсан юм гэнэ лээ.

-Цагаан эргийн хурал гэж?

Цагаан эргийн хурал гэж том хурал байсан. Зодын хурал гэсэн үг. Манай энд байсан жинхэнэ энэ нутгийн нэг хөгшин хэлж байсан их олон сайхан ламтай байсан гэж байсан байна.

-Долоодын хийдийн тухай юу сонссон бэ?

Бас л их сайхан том хурал байсан. Чухам хэр их ламтай байсныг мэдэхгүй. Хойд хуралдаа ч очиж байдаг байсан. Цагаан эргийн хуралдаа ч очиж л байсан. Төв аймгийн Баянжаргалан энэ тэрээс олон талаас очиж байсан гэдэг.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон